

САНГИЙН  
САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

ХУУЛЬ, ЗҮЙ  
ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Ч.УЛААН

Ц.НЯМДОРЖ

Төсөл

## ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

#### 1.1. Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэгт “Тариалангийн үйлдвэрлэлийг даатгалд хамруулах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна” гэж, Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаарбаримтлах бодлогын 6.1.5 дахь хэсэгт “эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх” гэж тус тус тусгасан. Мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “2.47.Тариалангийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлнэ.” гэж заасан.

#### 1.2. Практик шаардлага:

Улс орны хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүн амын хүнсний гол хэрэглээ болох тариалангийн бүтээгдэхүүнийг эрсдлээс хамгаалах даатгалын тогтолцоог бүрдүүлэх нь тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж “Үрийн тариалангийн даатгалын тухай” хуулийг Улсын Их Хурал 1999 онд баталсан.

Хууль батлагдсан тухайн үед тариалангийн салбар уналтанд орсноос үрийн тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа үндсэндээ зогсож, нөгөө талаас үндэсний даатгалын байгууллагууд санхүүгийн чадавхиас шалтгаалан үрийн тариалангийн эрсдэлийг даатгах чадваргүйгээс даатгах, даатгуулах сонирхол аль аль талдаа байхгүй болсон нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн.

Сүүлийн жилүүдэд төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны үр дүнд тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн тоо 2019 оны байдлаар 1401-д хүрч, жилдээ 800 гаруй тэрбум төгрөгийн тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна.

Дэлхийн цаг уурын дулаарлын улмаас байгалийн гамшиг, гэнэтийн аюул, эрсдлийн давтамж, тоо хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал, 2015 оны ургац хураалтын дүнгээр 108.4 мянган га талбайн ургацыг алдсан нь тариалсан талбайн 30 хувь буюу нийт ургацын 50 гаруй хувь болж байна. Мөн 2016 онд 32.3 мянган га-ийн үр тарианы ургац бүрэн алдагдаж, 20.4 тэрбум төгрөгийн хохирол учруулсан байна.

Эдгээр нөхцөл байдлаас харахад зөвхөн буудайн үрийн тариаланг бус үр тариа болон бусад таримлын тариаланг даатгах эрх зүйн орчныг бүрдүүлснээр газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тариаланчдын орлого, ашгийг болзошгүй эрсдлээс хамгаалах боломж бүрдэх юм.

### Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэ хуулийн зорилт нь тариалангийн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, тариалангийн үйлдвэрлэлийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, төрөөс тавих хяналт, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч, даатгагч болон давхар даатгагчийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тариалангийн эрсдлийг даатгуулах үйл ажиллагааны тусгайлсан онцлог харилцаа, түүнтэй холбогдсон Засгийн газар, даатгалын байгууллага болон тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд хооронд үүсэх харилцааг уг хуулиар зохицуулна.

Хуулийн төсөл нь нийтлэг үндэслэл, тариаланг даатгах, бусад зүйл гэсэн 3 бүлгээс бүрдэнэ.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, тариалангийн даатгалын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, тариалангийн даатгалын зарчим зэргийг тусгана.

Хоёрдугаар бүлэгт тариалангийн даатгалын төрөл, бүтээгдэхүүн, эрсдэл, хамгаалалтын хүрээ, хураамж, даатгалын сан, нөхөн төлбөр, даатгагч болон даатгуулагчийн эрх, үүргийг заана.

Даатгалын бүтээгдэхүүн нь индексжүүлсэн болон уламжлалт аль ч хэлбэрээр байж болох ба даатгалын бүтээгдэхүүнийг давхар даатгалын компани нэвтрүүлэхээр боловсруулна. Тариалангийн даатгалыг таримлын төрөл, ач холбогдлыг харгалзан албан журмын, эсхүл сайн дурын байхаар хуульчилна. Учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор үрийн тариалангийн тариалсан талбайг 100 хувь, стратегийн хүнс болох улаан буудайн тариалангийн тариалсан талбайн 10-аас доошгүй хувийг албан журмаар даатгах ба бусад таримлын хувьд сайн дурын даатгалд хамрагдах боломжтой байхаар тусгана. Даатгалын хамгаалалтын хүрээг албан журмын даатгалтай бол тухайн жилийн төлөвлөсөн ургацын үнэлгээний 80 хувь байхаар, харин сайн дурын даатгалын хувьд бол даатгагчтай байгуулах гэрээгээр тогтоохоор ялгамжтай зохицуулна.

Тариалангийн даатгалын эрсдлийг ган, үер, хүчтэй салхи, шуурга, мөндөр, хяруу, цас, цочир хүйтрэл, аадар бороо, үргэлжилсэн бороо, түймэр болон бүс, нутгийг хамарсан ургамлын гоц хөнөөлт өвчин, шавж, мэрэгчид байхаар тодорхойлно. Төрөөс тариалангийн даатгалын хураамжийг 50 хувь хөнгөлөхөөр заана. Үүнд зарцуулах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхээр зохицуулна. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данс байх ба энэ дансанд төрөөс үзүүлэх хураамжийн дэмжлэгийг төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гуравдугаар бүлэгт тариалангийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал**

Тариалангийн даатгалын тухай хууль батлагдснаар нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүнгүүд гарна:

- Тариалангийн даатгалын тогтолцоог бий болгох, даатгах, даатгуулах эрх зүйн орчин бий болно.
- Тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн гамшиг, гэнэтийн аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөл бүрдэнэ.
- Эрсдэл буурснаар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой хөгжихөд хувь нэмэр оруулна.
- Тариалангийн үйлдвэрлэл тогтворжиж, тариаланчдын хөрөнгө, санхүүгийн чадавхи сайжран, орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.
- Тариалангийн даатгалд оролцох тогтолцоо бүрдэж, улмаар даатгалын хүрээ өргөжин, улсын төсвийн орлого нэмэгдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал.**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Тариалангийн тухай хууль, Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулна. Мөн Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг боловсруулна.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь тариалангийн үйлдвэрлэлийг болзошгүй эрсдлээс хамгаалах, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, давхар даатгал, даатгагч болон даатгуулагчийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Тариалангийн даатгалын тухай хууль тогтоомж**

2.1. Тариалангийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Компанийн тухай, Статистикийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Тариалангийн даатгалд ил талбайн болон хамгаалагдсан тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд даатгуулж болно.

3.2. Тариалангийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад нийтлэг харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна.

3.3. Энэ хуульд дурдсан давхар даатгалын компанийн эрх зүйн байдлыг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулиар зохицуулна.

**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо**

4.1. Энэ хуульд хэрэглэсэн энэ хуулийн 4.2-т зааснаас бусад нэр томьёог Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд тус тус заасан утгаар ойлгоно.

4.2. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.2.1. “тариалангийн үйлдвэрлэл” гэж Тариалангийн тухай хуулийн 16.1, 16.2-т заасныг;

4.2.2. “тариалангийн даатгал” гэж төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу тариалангийн даатгалын хураамж төлж, тариалангийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, тариалангийн үйлдвэрлэлийг болзошгүй эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг;

4.2.3. “даатгуулагч” гэж энэ хуулийн дагуу даатгагчтай гэрээ байгуулан хураамж төлж, тариалангийн үйлдвэрлэлд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг.

**5 дугаар зүйл. Тариалангийн даатгалын үйл ажиллагааны зарчим**

5.1. Тариалангийн даатгалын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1. тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах;

5.1.2. тариалангийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

5.1.3. тариалангийн нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих.

ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ТАРИАЛАНГ ДААТГАХ**6 дугаар зүйл. Тариалангийн даатгалын төрөл**

6.1. Тариалангийн даатгал нь албан журмын болон сайн дурын даатгал гэсэн төрөлтэй байна.

6.2. Учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор тариалангийн албан журмын даатгалд дараахь тариаланг даатгуулна:

6.2.1. үрийн тариалангийн тариалсан талбайг 100 хувь;

6.2.2. улаан буудайн тариалангийн тариалсан талбайн 10-аас доошгүй хувийг.

6.3.Энэ хуулийн 6.2-т зааснаас бусад ил талбайн болон хамгаалагдсан тариаланг сайн дурын даатгалд хамруулж болно.

#### **7 дугаар зүйл. Тариалангийн даатгалын бүтээгдэхүүн**

7.1. Тариалангийн даатгалын бүтээгдэхүүн нь уламжлалт болон индексжүүлсэн байж болно.

7.2. Даатгалын бүтээгдэхүүнийг даатгагчтай зөвшилцсөний үндсэн дээр үндэсний давхар даатгалын компани тариалангийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

#### **8 дугаар зүйл.Тариалангийн даатгалын эрсдэл**

8.1. Тариаланг дараахь эрсдэлээс даатгана:

8.1.1.байгалийн эрсдэл: ган, үер, хүчтэй салхи, шуурга, мөндөр, хяруу, цас, цочир хүйтрэл, аадар бороо, үргэлжилсэн бороо, түймэр;

8.1.2. бүс, нутгийг хамарсан ургамлын гоц хөнөөлт өвчин, шавж, мэрэгчид.

#### **9 дүгээр зүйл.Даатгалын хамгаалалтын хүрээ**

9.1. Албан журмын даатгалын хамгаалалтын хүрээ тухайн жилийн төлөвлөсөн ургацын үнэлгээний 80 хувийг хариуцна.

9.2. Энэ хуулийн 6.3-т заасан сайн дурын даатгалд даатгуулах бол даатгагчтай байгуулах гэрээгээр хамгаалалтын хүрээг тогтооно.

9.3. Даатгалын гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн үндэсний давхар даатгал компани батална.

9.4. Тариалангийн даатгалын гэрээг тариалсан талбайн хэмжээ, байршлын зургийг үндэслэн тариалалт дууссан өдрөөс хойш 20 хоногийн дотор байгуулна.

#### **10 дугаар зүйл.Даатгалын хураамж**

10.1. Албан журмын, эсхүл сайн дурын эсэхээс үл хамааран даатгуулагч даатгалын хураамжийн 50 хувийг өөрөө, үлдсэн 50 хувийг Засгийн газар хариуцна.

10.2. Даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 10.3-т заасан журмын дагуу даатгагчид хамтран тогтооно.

10.3. Даатгалын хураамжтай холбогдсон журмыг даатгагчдын саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

10.4. Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг Даатгалын тухай хуулийн 14.2.5-д заасан аргачлалын дагуу даатгагч тогтооно.

#### **11 дүгээр зүйл. Тариалангийн даатгалын сан**

11.1. Энэ хуулийн 10.1-д заасан хөрөнгийг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр улсын төсөвт тусгаж тариалангийн даатгалын санг бүрдүүлнэ.

11.2. Тариалангийн даатгалын сан нь хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Хөдөө аж ахуйг дэмжих сангийн тусдаа бүртгэлтэй, бие даасан данс байна.

11.3. Тариалангийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төсвийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран жил бүр тогтооно.

11.4. Тариалангийн даатгалын сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журмыг төсвийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

#### **12 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөр**

12.1.Тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг даатгалын бүтээгдэхүүний төрлөөс хамааруулан гэрээгээр тогтооно.

12.2. Даатгалын тохиолдол үүссэн бол даатгагч даатгуулагчид нөхөн төлбөрийг бүрэн олгоно.

12.3. Даатгагч нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгохыг хориглоно.

12.4. Тариалангийн даатгалын хохирлыг тооцох аргачлалыг үндэсний давхар даатгал компани гаргана.

12.5.Тариалангийн даатгалын нөхөн төлбөртэй холбогдсон харилцааг Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

12.6. Даатгалын тохиолдол үүсээгүйн улмаас даатгуулагч хоёр жил дараалан нөхөн төлбөр аваагүй бол даатгагч гурав дахь жилээс эхлэн нөхөн төлбөр аваагүй жил тутамд тухайн жилийн даатгалын хураамжийн хэмжээг 5.0 хувиар бууруулан тооцно. Бууруулан тооцсон нь энэ хуулийн 12.2-т заасан нөхөн төлбөрийн хэмжээнд нөлөөлөхгүй.

### **13 дугаар зүйл. Даатгагчийн эрх, үүрэг**

13.1. Даатгалын компани /цаашид “даатгагч” гэх/ Даатгалын тухай хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан тохиолдолд тариалангийн даатгалын үйл ажиллагаанд оролцох эрхтэй:

13.1.1. Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

13.1.2. Үндэсний давхар даатгалын компанитай давхар даатгалын гэрээ байгуулсан байх.

13.2. Энэ хуулийн 9.3-т заасан даатгалын гэрээний загварыг хэрэглэх үүрэгтэй.

### **14 дүгээр зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг**

14.1. Даатгуулагч дараах эрхтэй:

14.1.1. энэ хуулийн 6.2-т заасан заавал даатгуулах энэ хуулийн 6.2-т зааснаас бусад таримлын төрөл, даатгалын бүтээгдэхүүнийг сонгон даатгуулах;

14.1.2. улаан буудайн тариалангийн тариалсан талбайгаас энэ хуулийн 6.2.2-т заасан хэмжээгээр сонгон даатгуулах;

14.1.3. даатгалын тохиолдол үүсэхэд нөхөн төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн авах.

14.2. Даатгуулагч дараах үүрэгтэй:

14.2.1. даатгуулагч даатгуулах таримлын төрөл, талбайн хэмжээ, байршил, ургацын хэмжээг үнэн зөв мэдээлэх.

14.2.2. энэ хуулийн 9.4-т заасан хугацааны дотор даатгалын гэрээг даатгагчтай байгуулах;

14.2.3. даатгалын хураамжийг даатгалын гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;

14.2.4. даатгалын тохиолдол үүссэн тухайд даатгагчид нэн даруй мэдээлэх.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **15 дугаар зүйл. Тариалангийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих**

15.1. Тариалангийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо болон давхар даатгалын компанийн удирдлага холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

### **16 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

16.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **17 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

17.1. Энэ хуулийг 20.. оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА

.....

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20.. оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1999 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Тариалангийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20.. оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

“3.6 Тариалангийн даатгалын харилцааг холбогдох хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалтын дугаарыг “3.7” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Тариалангийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20.. оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь заалтын “... дээшлүүлсэн” гэсний дараа “тариалангийн сайн дурын даатгалд хамрагдсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Тариалангийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг